



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 636

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
өлгөх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон, 217,838,120.00 (хоёр зуун арван долоон сая найман зуун гучин найман мянга нэг зуун хорин) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэл, Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны дарга Л.Даваабаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг бүртгэх ажлыг комисс томилон, холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;


2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ГАНБАТ

Б.ГАВАА

0002659

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн
686 дугаар тогтоолын хавсралт

Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг
дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төслийн нэгжээс нийлүүлсэн
Хөвсгөлийн Улсын тусгай хамгаалалттай газрын захиргааны хөрөнгөд бүртгэх жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглал -тад орсон он	Тоо хэмжээ (ширхэг)	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)
1	Зөөврийн ариун цэврийн байгууламж	2018	13	3 751 750,00	48 772 750,00
2	Өтгөн шингэнийг ялгадаг хуурайшуулах шийдэлтэй ариун цэврийн байгууламж	2018	9	13 000 000,00	117 000 000,00
3	А-2 загварын хогийн сав	2018	1	507 490,00	507 490,00
4	А-3 загварын хогийн сав	2018	1	1 187 490,00	1 187 490,00
5	А-4 загварын хогийн сав	2018	4	547 490,00	2 189 960,00
6	А-5 загварын хогийн сав	2018	5	872 490,00	4 362 450,00
7	А-6 загварын хогийн сав /Хатгал/	2018	1	4 322 490,00	4 322 490,00
8	А-6.1 загварын хогийн сав /Ханх/	2018	1	3 822 490,00	3 822 490,00
9	Нэвтрэх цэг дээрх самбар	2017	1	3 000 000,00	3 000 000,00
10	Мэдээллийн самбар /загвар-1/	2018	2	3 893 000,00	7 786 000,00
11	Мэдээллийн самбар /загвар-2/	2018	6	1 839 500,00	11 037 000,00
12	Отоглох цэгийн сууц	2008	1	13 850 000,00	13 850 000,00
	Нийт дүн	-	45	50,594,190.00 (тавин сая таван зуун ерэн дөрвөн мянга нэг зуун ерэн)	217,838,120.00 (хоёр зуун арван долоон сая найман зуун гучин найман мянга нэг зуун хорин)